

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН
АЖЛЫН ТАЙЛАН

2025.12.17

Эрдэнэт хот

2023 оны 05 дугаар сарын 04-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдаж тус хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Нийгмийн даатгалын газрын даргын 2023 оны А/24 тоот тушаалаар байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулан, доорх бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулан ажиллаж байна. 2025 оны IV дүгээр улиралын байдлаар Төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой 1 гомдол ирсэнийг ТАХ-ын Ёс зүйн тухай хууль, Ёс зүйн дэд хорооны ажиллаж журмын дагуу холбогдох ажиллагаа явуулж дүгнэлт гаргаж ажилласан.

д/д		Овог нэр	Албан тушаал
1.	Дарга	М.Дүүрэнжаргал	Тэтгэмжийн улсын байцаагч
2.	Гишүүн	Л.Эрдэнэсүвд	Орлого, шимтгэлийн улсын байцаагч
		Д.Дуламсүрэн	Хяналт, шалгалтын улсын байцаагч
		Б.Эрдэнэчимэг	Тэтгэврийн улсын байцаагч
3.	Нарийн бичгийн дарга	Д.Идэржавхлан	Хүний нөөцийн мэргэжилтэн

Ёс зүйн дэд хороо нь Төрийн албан хаагчдын сахилга хариуцлага, ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор шинээр батлагдан гарсан хууль, журам тогтоол шийдвэрүүдийг өөрийн байгууллагын онцлог, чиг үүрэгтэй уялдуулан жилийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын ажилтануудыг ёс зүйн зөрчлөөс урьдчлан сэргийлэх, харилцаа хандлагыг сайжруулах, байгууллагын соёлыг төлөвшүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор сургалт арга хэмжээнүүдийг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллалаа.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу:

Ёс зүйгээрээ манлайлья болзолт уралдааныг 05 дугаар сард зохион байгуулж Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс **“Хамгийн ёс зүйгээрээ манлайлагч хэлтэс”**-ээр шалгарсан.



"ЁС ЗҮЙГЭЭРЭЭ МАНЛАЙЛЪЯ" БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

/2025 оны 05 сарын 01-31 хүртэл/

1 ЗОРИЛГО:

Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх үнэт зүйлс, соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэхэд Нийгмийн даатгалын газрын хэлтэс, тасаг нийт албан хаагчдын оролцоог нэмэгдүүлэхэд уралдааны зорилго оршино.

ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖИЛ:

2

Төрийн албан хаагч үйл ажиллагаандаа дараах ёс зүйн хэм хэмжээг мөрдөн ажиллах ба тус болзолт уралдаанд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 7,8 дугаар зүйлийн хүрээнд шинэлэг арга хэмжээ зохион байгуулан ажиллана.

Үүнд пост, контент, постер, рийл, бусад шинэлэг ажил санаачлан оролцох.

3 УРАЛДААНЫ ҮР ДҮНГ НЭГТГЭХ, ТАЙЛАГНАХ, УРАМШУУЛАХ:

Нийгмийн даатгалын газрын хэлтэс, тасгууд уралдааны хугацаанд хийсэн ажлын тайланг Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд **2025 оны 06 дугаар сарын 05-ны дотор** цаасан хэлбэрээр ирүүлнэ. Үнэлгээг нийт хийсэн шинэлэг ажлын тоо болон хэлтэс, тасаг албан хаагчдаа бүрэн хамруулсан байдлаар дүгнэнэ.

**2025 оны 06 сарын 05-ны өдөр нийт
албан хаагчдад танилцуулан урамшуулмын
батламжийг гардуулна.**



Төрийн албан хаагчийн үйл ажиллагаа нь ямагт хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндийг дээдлэн, ард түмний итгэлийг бэхжүүлэхэд хуулийн хүрээнд хийгдэх шаардлага нийгмийн болон эрх зүйн зүгээс тавигддаг.

Нийгмийн уур амьсгал бүрэлдэн тогтоход ёс зүй нь хоёр талт нөлөө үзүүлсээр ирсэн. Ёс зүй цэвэр байвал нийгэмд эерэг нөлөө үзүүлж, хөгжин бэхжихийн нөхцөл болох бөгөөд хэрэв доройтвол сөрөг нөлөө үзүүлж, нийгэм уруудахын үндэс болдог. Иймээс ёс зүй нь нийгмийн харилцааны чухал хэлбэр бөгөөд хүмүүс хоорондоо харилцаа холбоо тогтоох, мэдээлэл солилцох, бие биедээ нөлөөлөх үйл явц нь соён гээгээрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

1. “Бид соёлыг бүтээнэ, бид соёлыг түгээнэ” Нөлөөллийн арга хэмжээ

Бид үргэлж хүмүүстэй уулзаж, танилцаж ажил хэргээ явуулдаг. Аливаа хүн анх уулзсан хүнээ 30 секундэд дүгнэдэг. Ийм богино хугацаанд бидэнд нөлөөлж чадах зүйл бол гадна төрх байдал буюу хувцаслалт юм. Тухайн газар хэлтсийн уур амьсгалыг тодорхойлно.

Тус газрын ажилтан албан хаагчдийн дунд ажиглалтын /далд/ аргаар бусдад нөлөөлж чадах ажилтан, албан хаагчийг шалгаруулах ажил зохион байгуулсан. Тус нөлөөллийн арга хэмжээнд Захиргаа хяналтын хэлтсийн дарга Г.Галбадрах түрүүллээ.



Зураг 1. Пост бэлтгэн байршуулсан

Үүнээс үзэхэд харилцааны соёл, биеэ авч явах байдлын /гадаад байдал, хувцаслалт, мэндлэх, ярих/ талаар газар, хэлтэс хяналт тавьснаар үйлчилгээний ёс зүйг хэвшүүлэх боломжтой.

2. “Та таа, тунгаа” Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн, ёс зүйн хэм хэмжээ, танин мэдэхүйн ойлголт өгөх зорилготой Хөгжөөнт тоглоом.

Ажлын байрны эерэг хандлагатай соёл, халуун дулаан уур амьсгал бол аливаа байгууллагыг амжилтанд хүргэх гол бүрэлдэхүүн хэсэг юм. Зөв соёл, хандлагыг байгууллагадаа хэвшүүлэх нь олон учир шалтгаантай. Ёс суртахууны төлөв байдлаас эхлүүлээд байгууллагадаа эерэг чиг хандлагатай соёлыг бий болгосноор байгууллага

эрүүл, баттай оршин тогтнож чадах бөгөөд ажилтан албан хаагчид эерэгээр бие биенээ харахад хөгжилдөх нь чухал нөлөөтэй юм.

Хөгжөөнт тоглоомыг 3 үе шаттай зохион байгуулсан. 5 хэлтсийг төлөөлж 10 ажилтан албан хаагч хамрагдсан.

1-р шат: Үгээр тайлбарлана, үгийн үндсийг хэлэхгүй. Танин мэдэхүйн

2-р шат: Авиа оруулж, үйл хөдлөлөөр үзүүлнэ, үгээр тайлбарлахгүй. Эв дүй, ур чадвар шаардана.

3-р шат: Ажил мэргэжилтэй холбоотой мэдлэг шалгах гэсэн 3 үе шаттайгаар хөгжөөнт тэмцээн явуулж шалгаруулсан.



Нийт оролцсон 5 баг


1-р байр Захиргаа хяналтын хэлтэс

2-р байр Хамралт орлогын хэлтэс

Ажилтнуудын дунд хөгжөөнт тоглоом тоглуулж бие биенээ зөвөөр мэдрэх, хөгжилдөх бусдыгаа эерэгээр харах, танихад чухал нөлөө үзүүлсэн. Ажлын дундуур бие биедээ урам өгөх, сэргээх уур амьсгалыг эрс өөрчилж чадах үйл явц болсон.

3. “Ёс зүй” сурталчилах рийл.

Ёс зүй гэдэг нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тавигдах ёс суртахууны өвөрмөц хэм хэмжээнээс гадна хүнлэг, энэрэнгүй байж ажил мэргэжлээ өндөр ур чадвартайгаар хийж гүйцэтгэхийг давхар шаарддаг билээ. Үүнд харагдах байдал ч чухал



Рийл

Ямар ч албан тушаалтан, албан хаагчид мэргэжил дээрээ алдахаас илүү ёс зүйн алдаа гаргах нь илүү байдаг. Ёс зүйн алдаа нь цаашлаад мэргэжлийн алдаанд хүргэдгийг санууштай.

4. “Авлига, ёс зүй” “Та өгөхгүй бид авахгүй”

"Авилга гэж албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхгүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчил" гэж тодорхойлогдсон байна. Төрийн байгууллага авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах үүрэгтэй.



Пост



Постер


Иргэн, төр нийтийн эрх ашгийг авлигаас хамгаална. Авлигын эсрэг нэгдье. Шудрага ёс, хөгжил дэвшилт та мэдээл 75776699 /8/ холбоос, авлигыг мэдээлэх утас 110.

5. АХА тэмцээн

Төрийн албан хаагчийн ёс зүйн зарчим, нийтлэг хэм хэмжээг тогтоох, сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчилах зорилгоор АХА тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулж уг тэмцээнд газрын нийт албан хаагч хамрагдаж 3 дугаар байранд тэтгэмж тогтоолт, олголтын байцаагч М.Дүүрэнжаргал, 2 дугаар байранд

хүний нөөц, хуулийн мэргэжилтэн Д.Идэржавхлан, тэргүүн байранд тэтгэвэр тогтоолт, олголтын байцаагч Б.Эрдэнэчимэг нар тус тус амжилттай оролцлоо.

Уг АХА тэмцээнд танин мэдэхүй, IQ, төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн асуултыг асууж тэмцээнээ амжилттай, хөгжөөнтэй зохион байгууллаа.











6. Ажлын цаг ашиглалт

Ажилчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулах хяналт тавих, идэвхижүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “өглөөг өөдрөг эхлүүлэх” ажлыг зохион байгуулж нийт ажилчдаа өглөөний кофе болон урмын үгээр хамтдаа эхлүүллээ. Хамгийн эхэнд ажилдаа ирсэн 5 байцаагч ажилчдад гарын бэлгээр урамшуулав. Хамгийн эхний ажилтан 07:30 цагт ирсэн бол хамгийн сүүлд 08:16 цагт ажилдаа ирсэн. Нийт ажилчдаас 24 байцаагч ажилчид өглөөний 08:00 цагаас өмнө

буюу цагтаа ирсэн нь 50%-ийн үзүүлэлттэй буюу хангалтгүй үзүүлэлттэй харагдаж байна.


Цагаасаа хоцорч ирсэн байцаагч ажилчдыг ажлын цагтаа ирж байхыг уриалан ажилласан.




<  Orhon Social In...   

 **О. Чойенмаа** 
★ Rising contributor · 16 May ·  Bodikhuu · 

“Ёс зүйгээрээ манлайлъя”

Төр түмнийхээ төлөө үнэнчээр зүтгэ... [See more](#)



   33

3 comments 307 views

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА.....М.ДҮҮРЭНЖАРГАЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА.....Д.ИДЭРЖАВХЛАН